

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/228-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Отгонбаяр

Утас: 70363047

Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11-12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12-13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13-14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	14-15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15-16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нотлох ажил
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-02-14 № СЭА-2022/228-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,009,162.00	10,191,377.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,009,162.00	10,191,377.00
35400	Хангамжийн материал	23,009,162.00	10,191,377.00
35420	Аж ахуйн материал	20,466,702.00	9,131,677.00
35440	Түлш, шатах тослох материал	2,542,460.00	1,059,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,035,153,011.75	1,203,870,112.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,035,153,011.75	1,203,870,112.08
39200	Биет хөрөнгө	991,058,592.10	1,160,642,045.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	916,099,057.01	1,049,878,122.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,332,543.23	-91,975,555.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	89,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,833,333.34	-27,138,888.93
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	136,251,290.80	148,838,864.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,030,452.65	-53,685,260.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	97,586,227.10	73,671,658.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-73,438,969.73	-37,081,656.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,227,164.70	11,227,164.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,701,508.56	-2,552,262.84
39217	Ном	231,660.00	459,860.00
39300	Биет бус хөрөнгө	44,094,419.65	43,228,066.68
39301	Програм хангамж	1,245,411.80	1,245,411.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	-269,392.15	-1,135,745.12
39303	Бусад биет бус хөрөнгө	43,118,400.00	43,118,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,058,162,173.75	1,214,061,489.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,058,162,173.75	1,214,061,489.08
51	Засгийн газрын хувь оролцоо	1,058,162,173.75	1,214,061,489.08
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	363,793,993.87	363,793,993.87
51200	Хуримтлагдсан үр дүн	102,005,143.18	257,904,458.51
51210	Өмнөх үеийн үр дүн	53,482,747.70	102,005,143.18
51220	Тайлант үеийн үр дүн	48,522,395.48	155,899,315.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	592,363,036.70	592,363,036.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,058,162,173.75	1,214,061,489.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,284,311,213.66	1,361,731,747.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,153,113.66	252,482,747.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,153,113.66	252,482,747.00
120009	Бусад орлого	69,775,706.66	32,203,407.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	23,533,707.00	215,795,020.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	843,700.00	4,484,320.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,190,158,100.00	1,109,249,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,190,158,100.00	1,109,249,000.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,190,158,100.00	1,109,249,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,235,788,818.18	1,201,460,505.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,788,818.18	1,201,460,505.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,146,318,941.59	1,172,541,284.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,425,151.31	823,220,692.00
210101	Үндсэн цалин	672,241,401.31	637,198,576.00
210102	Нэмэгдэл	134,131,352.00	133,082,875.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,123,570.00	25,950,000.00
210104	Урамшуулал	22,928,828.00	26,989,241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,429,337.00	107,665,821.28
210201	Тэтгэврийн даатгал	74,923,498.94	75,110,719.14
210202	Тэтгэмжийн даатгал	8,626,959.50	8,318,533.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,901,567.61	6,580,906.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,723,391.91	1,605,060.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,253,919.04	16,050,602.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,764,441.10	62,822,752.00
210301	Гэрэл, цахилгаан	45,995,541.10	54,053,300.00
210303	Цэвэр, бохир ус	5,768,900.00	8,769,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,665,585.00	60,449,605.00
210401	Бичиг хэрэг	12,769,118.00	11,918,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,452,540.00	9,692,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,482,200.00	11,182,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	618,600.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,343,127.00	27,563,345.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	17,756,000.00
210604	Урсгал засвар	30,000,000.00	17,756,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,040,000.00	3,660,000.00
210702	Дотоод албан томилолт	4,040,000.00	3,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,926,112.00	4,557,014.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	823,170.00	3,366,703.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	476,010.00	747,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,564.00	111,564.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	37,368.00	39,747.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,068,315.18	92,409,400.39
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,068,315.18	92,409,400.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,469,876.59	28,919,220.72

2132	Бусад урсгал шилжүүлэг	30,589,000.00	2,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,589,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,880,876.59	26,919,220.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,880,876.59	26,919,220.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	48,522,395.48	160,271,241.61
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	4,371,926.28
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	4,371,926.28
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	48,522,395.48	155,899,315.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,190,158,100.00	1,109,249,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,190,158,100.00	1,109,249,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,190,158,100.00	1,109,249,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,190,158,100.00	1,109,249,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,185,158,100.00	1,091,749,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,185,158,100.00	1,091,749,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,095,688,223.41	1,062,829,779.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,425,151.31	823,220,692.00
210101	Үндсэн цалин	672,241,401.31	637,198,576.00
210102	Нэмэгдэл	134,131,352.00	133,082,875.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,123,570.00	25,950,000.00
210104	Урамшуулал	22,928,828.00	26,989,241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,429,337.00	107,665,821.28
210201	Тэтгэврийн даатгал	74,923,498.92	75,110,719.14
210202	Тэтгэмжийн даатгал	8,626,959.52	8,318,533.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,901,567.61	6,580,906.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,723,391.91	1,605,060.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,253,919.04	16,050,602.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,764,441.10	62,822,752.00
210301	Гэрэл, цахилгаан	45,995,541.10	54,053,300.00
210303	Цэвэр, бохир ус	5,768,900.00	8,769,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,303,182.00	37,403,500.00
210401	Бичиг хэрэг	12,740,182.00	11,918,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,675,700.00	8,209,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,482,200.00	11,182,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	618,600.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,786,500.00	6,000,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	1,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,200,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	22,300,000.00
210604	Урсгал засвар	30,000,000.00	22,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,040,000.00	3,660,000.00
210702	Дотоод албан томилолт	4,040,000.00	3,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,926,112.00	4,557,014.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	823,170.00	3,366,703.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	476,010.00	747,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,564.00	111,564.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	247,500.00
210807	Газрын төлбөр	37,368.00	39,747.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,469,876.59	28,919,220.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,589,000.00	2,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,589,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,880,876.59	26,919,220.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,880,876.59	26,919,220.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,000,000.00	17,500,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,000,000.00	17,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	17,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	17,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	17,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,000,000.00	-17,500,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	53,482,747.70	1,009,639,778.27
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	53,482,747.70	1,009,639,778.27
9	Тайлант үеийн үр дүн	0	0	48,522,395.48	48,522,395.48
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	102,005,143.18	1,058,162,173.75

11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	102,005,143.18	1,058,162,173.75
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	102,005,143.18	1,058,162,173.75
19	Тайлант үеийн үр дүн	0	0	155,899,315.33	155,899,315.33
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	257,904,458.51	1,214,061,489.08

МОНА0065 9055436

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,109,249,000.00	1,082,329,779.28	26,919,220.72	97.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,109,249,000.00	1,082,329,779.28	26,919,220.72	97.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,107,249,000.00	1,080,329,779.28	26,919,220.72	97.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842,803,300.00	823,220,692.00	19,582,608.00	97.68
210101	Үндсэн цалин	661,878,600.00	637,198,576.00	24,680,024.00	96.27
210102	Нэмэгдэл	140,007,600.00	133,082,875.00	6,924,725.00	95.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,606,900.00	25,950,000.00	(343,100.00)	101.34
210104	Урамшуулал	15,310,200.00	26,989,241.00	(11,679,041.00)	176.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,692,400.00	107,665,821.28	7,026,578.72	93.87
210201	Тэтгэврийн даатгал	81,070,700.00	75,110,719.14	5,959,980.86	92.65
210202	Тэтгэмжийн даатгал	8,405,400.00	8,318,533.24	86,866.76	98.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,964,300.00	6,580,906.72	383,393.28	94.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1,441,100.00	1,605,060.08	(163,960.08)	111.38
210205	Эрүүл мэндийн даатгал	16,810,900.00	16,050,602.10	760,297.90	95.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,823,200.00	62,822,752.00	448.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	54,053,300.00	54,053,300.00	0.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	8,769,900.00	8,769,452.00	448.00	99.99
2104	Хангамж, бараа материалын зардал	37,409,900.00	37,403,500.00	6,400.00	99.98
210401	Бичиг хэрэг	11,918,000.00	11,918,000.00	0.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	8,209,700.00	8,209,700.00	0.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,182,200.00	11,182,200.00	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	93,600.00	6,400.00	93.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	6,000,000.00	0.00	0.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	1,200,000.00	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,200,000.00	0.00	0.00

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,800,000.00	39,800,000.00	0.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,500,000.00	17,500,000.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	22,300,000.00	22,300,000.00	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	3,743,000.00	3,660,000.00	83,000.00	97.78
210702	Дотоод албан томилолт	3,743,000.00	3,660,000.00	83,000.00	97.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,777,200.00	4,557,014.00	220,186.00	95.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,581,700.00	3,366,703.00	214,997.00	94.00
210803	Даатгалын үйлчилгээ	747,500.00	747,500.00	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,600.00	111,564.00	4,036.00	96.51
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	247,500.00	0.00	0.00
210807	Газрын төлбөр	40,900.00	39,747.00	1,153.00	97.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,109,249,000.00	1,082,329,779.28	26,919,220.72	97.57
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,109,249,000.00	1,082,329,779.28	26,919,220.72	97.57
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,109,249,000.00	1,082,329,779.28	26,919,220.72	97.57
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	87	79	8	90.80
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5	0	100.00
610001	Төсвийн байгууллага	5	5	0	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	37	4	90.24
620001	Удирдах ажилтан	5	5	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32	29	3	90.63
620003	Үйлчлэх ажилтан	4	3	1	75.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	37	4	90.24
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17	17	0	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0	100.00
650012	Шүүгч, прокурор	14	10	4	71.43

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газрын /цаашид Шүүхийн тамгын газар гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалыг зарцуулахдаа албан хаагч тус бүрээр шаардах хуудас бичүүлж, олгож байх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн Тамгын газрын эрхэм зорилго нь “Шүүгчийн болон шүүхийн бие даасан хараат бус байдлыг ханган ажиллах”-д оршино.

Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөц, шүүхийн судалгаа, мэдээлэл, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах,
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих,
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх,
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах,
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах,
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Шүүхийн тамгын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 66 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг тус газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт хийж, бүртгэл тайлагналтай холбоотой 3 зөвлөмж, цалин хөлстэй холбоотой 4 төрлийн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,235,788.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу

18,536.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 13,902.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 155,899.3 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	23,009.20	10,191.40	-12,817.80
Үндсэн хөрөнгө	1,035,153.00	1,203,870.10	168,717.10
Нийт хөрөнгө	1,058,162.20	1,214,061.50	155,899.30
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,058,162.20	1,214,061.50	155,899.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,058,162.20	1,214,061.50	155,899.30

Бараа материалын дансны үлдэгдэл 10,191.4 мянган төгрөг болж 12,817.8 мянган төгрөгөөр буурсан нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн тогтоолоор 10,667.6 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж, эхний үлдэгдлээс 2,150.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, түлш, шатах тослох материал зарцуулснаас тус тус шалтгаалжээ. ШЕЗ-өөс нийт 464.3 мянган төгрөгийн вирусийн программ болон ном, гарын авлага, аймгийн ЗДТГ-аас 4,020.0 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй шилжүүлэн авсныг бараа материал дансанд орлого авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,417,439.5 мянган төгрөг болж 184,680.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 265,498.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/2110 дугаар тогтоолоор 80,818.1 мянган төгрөгийн хөрөнгө актлагдсантай холбоотой байна.

Тайлант онд нэмэгдсэн хөрөнгийг дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл төсвийн санхүүжилтээр 17,500.0 мянган төгрөгийн принтер, скайнер, эйр кондешн, Гэрэг D киоск машин, зургийн аппарат худалдан авч, шүүгчдийн хандиваар 6,650.0 мянган төгрөгийн ариутгалын хаалга, ШЕЗ-өөс 133,779.1 мянган төгрөгийн барилгын гадна фасад засвар, 62,000.0 мянган төгрөгийн Daster-HS маркын суудлын автомашин, 13,137.7 мянган төгрөгийн 7 ширхэг компьютер, 228.2 төгрөгийн ном орлого авсан бөгөөд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж боломжтой хөрөнгүүдийг 32,203.4 мянган төгрөгөөр дахин үнэлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,214,061.5 мянган төгрөг болж 155,899.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Шүүхийн тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 77,420.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад орлого буюу ТӨБЗГ-ын 2021 оны 509 дүгээр тогтоолоор 73 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэлгээ өмнөх оны дүнгээс 37,572.3 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 80,909.1 мянган төгрөгөөр тус тус буурсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 195,901.9 мянган төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 34,328.3 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан нь тайлант онд 2 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарч, нөхөн томилгоо хийгээгүйгээс цалингийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,702,441.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 560,985.3 мянган төгрөгөөр бууруулж 1,141,456.5 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулсан эсэхийг тулган баталгаажуулахад нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан 182,876.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшлын зардал илүү төлөвлөгдсөн байна.

Тайлант онд батлагдсан төсөвт 2 удаа зохицуулалт хийж, 2021 оны 12-р сард 32,207.5 мянган төгрөгөөр бууруулан 1,109,249.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь цалингийн зардлыг 48,223.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 3,784.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, эд хогшил, урсгал засварын зардлыг 19,800.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,109,249.0 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,082,329.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,082,329.8 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 26,919.2 мянган төгрөгөөр хэмнэж, оны эцэст төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130005401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад онцлох ажил гүйлгээ, асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шүүхийн тамгын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 148 мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,191.4 мянган төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага, 806.1 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	6,191.4	1	6,191.4	100

Зөвлөмж	2	806.1	2	806.1	100
Нийт дүн	3	6,997.5	3	6,997.5	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар бүх ажил гүйлгээг тулган баталгаажуулах боломжгүй байсан бөгөөд дараагийн аудитаар амралтын болон нэмэгдэл цалингийн тооцоолол, бараа материалын зарцуулалтыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1. Илрүүлэлт: Тус газар нь 6,818.2 мянган төгрөгийн хангамжийн материалыг зарцуулахдаа шаардах хуудсыг албан хаагч тус бүрээр бус нярав, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн нарын нэр дээр бөөн дүнгээр бичиж, тайлагнасан байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6 “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.” гэж заасны дагуу бараа материалыг зарцуулахдаа тухай бүр эд хариуцагч, албан хаагч тус бүрээр шаардах хуудас үйлдүүлж, холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа олгож байх.

1.2.1 Илрүүлэлт: Тайлант онд 8,576.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин

давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасны дагуу заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүхийн тамгын газар	2	15,395.0	-	-	-	-	-	-	2	15,395.0